

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН ЭНХ ТАЙВАН,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨӨ БҮСИЙН
БАГА ХУРАЛ**

1983 оны 4-р сарын 26—28-нд Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлын төлөө бүсийн бага хурал Улаанбаатар хотод болов. Бага хурал 1983 оны 6-р сард БНСЧСУ-ын нийслэл Прага хотноо болох «Энх тайван, аж амьдралын төлөө, цөмийн дайны эсрэг» дэлхий дахины Ассамблейг угтан зохиож байгаа томоохон ажил юм. Олон улсын байдал ихээхэн түгшүүртэй байгаа одоо үед манай гаригийн сайн санаат бүх хүн энх тайвны төлөө, дайн түрэмгийллийн эсрэг хүч чармайлтаа нэгтгэхэд эдгээр арга хэмжээнүүд чухал үе шат болж байна.

Бүсийн бага хуралд БНМАУ, ЗСБНХУ, БНСВУ, БНАЛАУ, БНКАУ, БНААфГУ, Энэтхэг, Сири, Бангладеш, Ирак зэрэг Ази, Номхон далайн 30-аад орны олон нийтийн төлөөлөгчид, дэлхийн энх тайвны зөвлөл, Ази, Африкийн эв санааны нэгдлийн байгууллага, дэлхийн үйлдвэрчний эвлэл, дэлхийн ардчилсан залуучуудын холбоо, дэлхийн ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо зэрэг олон улсын арваад байгууллагын төлөөлөгчид, ах дүү социалист орнуудын энх тайван, эв санааны нэгдлийн үндэсний байгууллагын төлөөлөгчид оролцлоо.

Хурлын ажиллагааг бүсийн бага хуралд бэлтгэх үндэсний хорооны дарга Д. Цэвэгмид нээж үг хэлэв.

Дараа нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалаас бүсийн бага хуралд оролцогчдод ирүүлсэн илгээлт болон БНСВУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Фам Ван Донг, АААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНААфГУ-ын хувьсгалт зөвлөлийн дарга Бабрак Кармаль, ПЧБ-ын дарга Ясир Арафат нараас бүсийн бага хуралд ирүүлсэн илгээлтийг тус тус уншиж сонсоход цугларагчид халуун дотно хүлээж авлаа.

Ази, Номхон далайн энх тайван аюулгүй байдлын төлөө бүсийн бага хурал дээр Дэлхийн Энх тайвны Зөвлөлийн ерөнхийлөгч Ромеш Чандра баяр хүргэж үг хэлэв. Ромеш Чандра бага хурал тус тивийн түүхэнд нэн хариуцлагатай үед, чухам яг зохимжтой оронд болж байна гээд Ази, Номхон далайн орнуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц байгуулах талаар БНМАУ-ын засгийн газраас дэвшүүлсэн санал нь өнөө үед энэ бүс нутагт төдийгүй, дэлхий дахины хувьд маш чухал гэдгийг онцлон тэмдэглэв.

Дэлхийн хүн амын тэн хагасаас илүү нь аж төрдөг өргөн уудам Ази тивийг сайн хөршийн харилцаа, итгэлцэл, хамтын ажиллагааны бүс нутаг болгох эрмэлзэл энх тайвныг эрхэмлэгч хүчний үйл ажиллагаа, тэмцлийн чиг бодлогод онцгой чухал байр эзэлж байна.

Империалист бүлгийнхний, юуны өмнө АНУ-ын харгис бодлого, балмад явууллагын уршгаар олон улсын хоорондын байдал, түүний дотор Азийн байдал улам түгшүүртэй болж байна. Гэвч Азийн улс түмэн эрх чөлөө, энх тайвны төлөө чухам яаж тулалдахын үлгэр дууриалыг Вьетнамын ард түмний аугаа их ялалт, Афганистаны дөрөвдүгээр сарын

хувьсгал, хэлмэгдэн зовж байгаа Палестины ард түмний баатарлаг тэмцэл харуулж байна гэж Ромеш Чандра тэмдэглэв.

Сүүлийн үед Зүүн өмнөд Азид байдал түгшүүртэй болж БНКАУ болон Энэтхэг-хятадын хойгийн бусад орны эсрэг Америкийн империализм Тайландыг ашиглаж, БНСВУ-д умар зүгээс, өөрөөр хэлбэл БНХАУ-аас халдан түрэмгийлэх аюул заналхийлж байгааг Дэлхийн Энх Тайвны Зөвлөлийн ерөнхийлөгч анхааруулав.

Хуралдаан дээр Дэлхийн Энх Тайвны Зөвлөлийн тэргүүлэгч гишүүн, МЭТНБХ-ны Гүйцэтгэх хорооны дарга, Энх тайвныг хамгаалах монголын хорооны дарга Н. Лувсанчүлтэм «Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалъя» гэсэн илтгэл тавилаа. Илтгэгч Ази тивийн байдал ноцтой хүндэрч байгаа өнөөгийн бодит шалтгааныг хөндөн яриад социалист орнууд, юуны өмнө ЗХУ-ын цуцалтгүй тууштай тэмцэл нь бүх нийтийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, Ази болон дэлхий дахины улс түмний эрх чөлөө, үндэсний тусгаар тогтнолыг хамгаалах үйл хэрэгт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэв.

Хуралд Зөвлөлтийн төлөөлөгч Каноатов, БНСВУ-ын төлөөлөгч Чан Хаой Нам, БНАСАУ-ын төлөөлөгч Ким Ен Сик, БНАЙАУ-ын төлөөлөгч Шафел Омар-Али, Шри Ланкийн төлөөлөгч Листоруге Арияванса, Монголын эмэгтэйчүүдийн хорооны дарга Л. Пагмадулам, Азийн буддистуудын энх тайвны бага хурлын ерөнхийлөгч хамба лам Гаадан, Дэлхийн үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөгч Пал Гергели, Дэлхийн ардчилсан залуучуудын холбооны төлөөлөгч Салем Алтамими зэрэг олон хүн үг хэлэв.

Бага хуралд оролцогчид БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалд явуулах илгээлтийг санал нэгтэй баталсан ба тус бага хурлаас Азийн улс түмэн, сайн санаат бүх хүнд хандаж уриалга гаргалаа.

Мөн Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлын төлөө бүсийн бага хуралд оролцогчид «Төгсгөлийн тунхаглал» баталж, удахгүй Прага хотноо «Энх тайван, аж амьдралын төлөө, цөмийн дайны эсрэг» уриан доор болох дэлхий дахины ассамблейд явуулах илгээлт, Цөмийн дайны аюулыг зайлуулах, зэвсэг хураах тухай зэрэг хэд хэдэн тогтоол батлав.

Ази, Номхон далайн энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө бүсийн бага хуралд оролцсон гадаадын зарим төлөөлөгчдөөс манай сэтгүүлийн редакцийн зөвлөл сэтгэгдэл авсан юм. Уг сэтгэгдлийг сэтгүүлийн энэ удаагийн дугаарт оруулж уншигч та бүхэндээ толилуулж байна.

Ази, Африкийн эв санааны нэгдлийн байгууллагын төлөөлөгч Ева Ранавера

1. Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай Конвенц байгуулах БНМАУ-ын саналын талаар та юу ярьж болох байна?

Өнөөгийн олон улсын хурцадмал байдлын үед БНМАУ-ын дэвшүүлсэн Ази, Номхон далайн районы улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай Конвенц байгуулах саналд Ази-Африкийн улс түмний эв санааны нэгдлийн байгууллага баяр хүргэн өндрөөр үнэлж байна. Энэ санаачилга нь Ази болон Номхон далайн бүс нутагт энх тайван, намжмал байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж бид үзэж байна.

Рейганы засаг захиргаа хүйтэн дайны бодлогыг сэргээхээр улайран зүтгэж байгаа өнөөгийн нөхцөлд БНМАУ-аас дэвшүүлсэн санал нь манай гаригийн хүн төрөлхтний соёл, иргэншлийг дайны аюул заналаас хамгаалахад чухал ач холбогдолтой болж байна.

Улс түмний хүчин чармайлтыг дайчлах энэ саналыг НҮБ-ын хурал чуулган болон эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний бага хуралд оруулах нь зүйтэй юм.

Учир нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хурал чуулган, мөн эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний бага хурал нь даян дэлхийн энх тайвны төлөө хүчин чармайлтыг эрчимжүүлэхэд чиглэгдсэн чухал хэрэглүүр болох тул тэдгээр нь Ази, Номхон далайн бүс нутагт намжмал байдлыг тогтооход зохих хувь нэмрээ оруулах боломжтой билээ.

2. Олон улсын одоогийн нөхцөлд Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар юу хийвэл зохино гэж та үзэж байна?

Түрэмгий бодлогыг хориглох, улс орнуудын хооронд харилцан ашигтай эдийн засгийн болон соёлын харилцаа хөгжүүлэх нь энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал юм. Бүрэн эрхт улс орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох явдлыг бүрэн зогсоохыг мөрдлөг болгож тулгамдсан асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх нь энх тайван, аюулгүй байдлыг хамгаалан бэхжүүлэхэд тус нэмэр болох юм. Олон улсын хурцадмал байдлыг намжаах, хэлэлцээ хийх, энх тайвнаар зэрэгцэн орших нь сүүлийн 20 жилд энх тайвныг хамгаалахын төлөө бидний явуулсан тэмцлийн зарчим болж ирэв. Энх тайвны эдгээр амин чухал зарчмуудыг хэрэгжүүлэхэд улс орон бүрийг татан оруулах нь чухлаас чухал байна.

**Дэлхийн энх тайвныг хамгаалах Вьетнамын хорооны тэргүүлэгч
гишүүн, Вьетнамын бүх орны ард түмэнтэй эв нэгдэл,
найрамдлыг бэхжүүлэх Хорооны ерөнхий нарийн бичгийн
Дарга Чан Хаой Нам**

1. Зүүн өмнөд Азийн энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхэд юу тус болж, юу гол саад болж байна гэж та үзэж байна?

Миний бодоход яриа хэлэлцээ, улмаар харилцан ойлгох, хамтран ажиллах, мөн үндэсний тусгаар тогтнол, биеэ даасан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал үндэсний эрх ашгийг харилцан хүндэтгэх, түүнчлэн улс гүрний хоорондын маргаантай аливаа асуудлыг хэлэлцээ хийх, энхийн замаар зохицуулах хүсэл шийдвэртэй байх нь Зүүн Өмнөд Азийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд идэвхтэй тус нэмэр болохсон билээ.

Нөгөөтэйгүүр, хагарал үүсгэх, Зүүн Өмнөд Азийн улсуудын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох, өдөөн хатгах, дайн дажингаар заналхийлэх, хүч хэрэглэх, яриа хэлэлцээнээс татгалзах зэргээр илэрдэг империалист эзлэн түрэмгийлэгч, жанжлагч санаархал бол үүнд тогтмол саад бэрхшээл учруулж байгаа юм.

2. Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлын төлөө бүсийн бага хурлын ач холбогдлын талаар та сэтгэгдлээ ярина уу?

ЗХУ, социалист орнууд болон дэвшилт хүчнээс цэргийн талаар давуу байдалтай болох зорилгоор АНУ-ын империалист дайнч бүлгийнхэн зэвсгээр улайран хөөцөлдөж байгаагийн уршгаар олон улсын байдал нэн хурцдаж, цөмийн дайны аюул занал бодитой болоод байна.

Энэхүү нийт байдал Ази тивд тусгагдаж түгшүүр үлэмж нэмэгдэж байна. Энд империалист санаархлын хамт жанжлагч бүлгийнхэн, орон нутгийн харгис хүчний явууллага байгаа юм.

Ийм нөхцөл байдалд Улаанбаатарын бүсийн бага хурал нь Ази, Номхон далайн энх тайван, тогтвортой байдлын үйлсэд туйлын чухал ач холбогдолтой бөгөөд дайн дэлхийн энх тайванд их хувь нэмэр болж байна. Ойрын ирээдүйг авч үзвэл, энэ бүсийн бага хурал нь 1983 оны зургадугаар сард Прага хотноо болох «Энх тайван, амьдралын төлөө, цөмийн дайны эсрэг» дэлхий дахины Ассамблейн бэлтгэл ажилд идэвхтэй тус дөхөм үзүүлэх болно.

БНААфГУ-ын энх тайван, найрамдал, эв санааны байгууллагын төлөөлөгч Ахмад Кабир Аmani

1. БНААфГУ-ын талаар харгис хүчний баримталж байгаа бодлогын талаар ярьж өгнө үү?

Их зовлон эдэлсэн манай ард түмний хөгжил цэцэглэлтэд чиглэгдсэн дөрөвдүгээр сарын хувьсгал нь АНУ тэргүүтэй дэлхийн империалист харгис хүчний зэвүүцлийг төрүүлсэн юм. Тэгээд ч тэд таван жилийн турш бидний эсрэг зарлаагүй дайн хийж, хүч хөрөнгө хайрлалгүй хувьсгалын эсэргүүчүүдийг зэр зэвсэг болон бусад хэрэгцээт зүйлээр хангаж байна.

Пакистаны нутаг дэвсгэрт АНУ-ын Тагнуулын төв газар хувьсгалын эсэргүү дээрэмчдийг бэлтгэх лагериудыг байгуулж, тэнд бэлтгэгдсэн дээрэмчдийг Афганистанд илгээдэг юм. Империалистүүдийн хүч хөрөнгөөр бүрэн зэвсэглэсэн дээрэмчдийн бүлэгүүд Афганистаны нутаг дэвсгэрт нэвтрэн орж, энгийн номхон хүн ардыг алан хядаж, зам гүүрийг дэлбэлж, тариан талбай сургууль, эмнэлэг, орон сууцны барилга, байшинг шатаан, усжуулах систем, харилцаа холбоо, цахилгаан дамжуулах шугамыг таслан устгаж байна. Дээрэмчдийн ийм хорлон сүйтгэх ажиллагааны уршгаар 2000 гаруй сургууль, 80 эмнэлэг зэргийг устгаснаар манай улсад 24 млрд афганын хохирол учруулсан юм. Түүний хамтаар барууны суртал нэвтрүүлэг манай оронд хэрэгжиж буй хувьсгалт өөрчлөлтийн эсрэг худал хуурмаг суртал нэвтрүүлгийн компани дэгдээж байна. Тухайлбал дайсны радио станцууд манай ард түмэн, хувьсгалын эсрэг нэвтрүүлгийг манай бүх үндэстний хэлээр өдөрт 95 цагаас илүү явуулж байна. Баттай мэдээгээр афганистаны хувьсгалын эсэргүү дээрэмчид бэлтгэх зорилгоор АНУ албаны шугамаар зөвхөн энэ онд гэхэд л 100 сая илүү доллар зарцуулахаар төлөвлөж байна. АНУ болон түүний холбоотнууд манай улсын эсрэг түрэмгийлэл, алан хядлага явуулахад зориулан өнгөрсөн хугацаанд нийтдээ нэг миллиардаас илүү доллар зарцуулаад байгааг албан ёсны мэдээ баримт нотолж байна.

Тэд ард түмний эсрэг, хувьсгалын эсрэг бодлого явуулан Афганистаныг энх тайван, дэвшил, ардчилалын лагериас салган хуучин дэглэмийг сэргээн тогтоохыг оролдож байна. Америкийн империализм болон түүний харгис холбоотнуудын зүгээс явуулж буй иймэрхүү явууллага нь манай улсын энх тайван, аюулгүй байдалд бодит аюул занал учруулж байна.

2. Дөрөвдүгээр сарын хувьсгал ялснаас хойшхи 5 жилд Афганистаны ард түмний олсон ололт амжилтын талаар ярьж өгнө үү!

Хүнд бэрх байдал тохиолдож байгаа хэдий боловч шинэ амьдрал цогцлон байгуулах, нийгмийг ардчилан шинэчлэх үйл явц хэлбэрэлтгүй урагшлан хөгжиж байна. Манай улсын амьдралын бүхий л салбарт

хувьсгалт өөрчлөлт гүнзгийрэн явагдаж байна. Хувьсгал өргөн олон түмний идэвхийг оргилуулав. Хөдөлмөрчдийн шууд оролцоотойгоор газрын шинэтгэл явагдаж, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх асуудал шийдвэрлэгдэн, үүний үндсэн дээр ард түмний аж амьдралыг сайжруулах боломж бүрдэж байна. Манай улсын 21 мужид газрын шинэтгэл хэрэгжив. Түүнд газаргүй ба бага газартай 1,57 сая тариачны эрх хамаарагдаж байна. Түүний хамтаар тариачдад улсаас санхүүгийн тусламж үзүүлдэг бөгөөд тийм тусламжийг одоогоор 3,5 сая хүн авсан. Түүнээс гадна тариачид улсаас газар тариалангийн багаж хэрэгсэл, үрийн тариа, бордоо зэрэг тусламж өсч байна. Саяхан хүртэл феодалын өмнөх үеийн болон феодалын харилцаа ноёрхож байсан манай орны нөхцөлд тариачдыг хоршооллох нь шинэ бөгөөд, асар их ирээдүйтэй үйл хэрэг юм. 1982 он гэхэд 1200 гаруй хоршоолол байгуулагдаж гишүүдийн тоо нь 200 мянгаас давлаа.

Бичиг үсэг мэдэхгүй явдлыг устгах, ардын боловсрол, эрүүлийг хамгаалахыг хөгжүүлэх талаар их ажил хийгдэж байна. Бичиг үсэгт сургах 31625 курст 632500 хүн суралцаж байна. Энэ оны төлөвлөгөөгөөр энэ тоог 20 хувиар нэмэгдүүлэх юм.

Олон түмний нийгэм-улс төрийн идэвх нэмэгдэн манай оронд залуучууд, эмэгтэйчүүд, үйлдвэрчин, хоршооллын байгууллага, сэхээтний уран бүтээлийн холбоонууд байгуулагдав. Хөдөлмөрчин олон түмний эдгээр байгууллагууд нь АААН-ын удирдлагын дор улс оронд хэрэгжиж байгаа дэвшилт өөрчлөлтөд үндэсний эх орны фронтын хүрээнд идэвхтэй оролцож байна.

Тус оронд үндэстний асуудал анх удаа шийдвэрлэгдэж байна. АААН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНААфГУ-ын Хувьсгалт Зөвлөлийн дарга Бабрак Кармаль хэлэхдээ «АААН болон БНААфГУ-ын засгийн газрын өмнө тавигдаж буй чухал асуудлын нэг нь Афганистанд үндэстний асуудлыг шийдвэрлэн, үндэстний ард түмнүүдийн тэгш эрхийг ханган, хөгжүүлэн цэцэглүүлэх явдал юм» гэжээ. 1979 онд батлагдсан «АААН-ын үндсэн зарчмууд»-ад Афганистан дахь бүх үндэстэн, ястны тэгш эрх тусгагдсан юм. Одоо Афганистанд оршин суудаг ард түмнийг бие биендээ харгалдуулан муудалцуулахыг арилгах талаар тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Урьд хувьсгалын эсэргүү дээрэмчдийг толгойлж байсан 280 хүн хувьсгалын талд орсон баримт нь манай намаас ард түмний аж амьдралыг сайжруулах, эх оронч бүх хүчнийг тус орныг цэцэглүүлэн хөгжүүлэхийн төлөө тэмцэлд татан оролцуулах бодлого явуулж байгааг ухааран ойлгож байгаагийн гэрч боллоо.

Кампучийн энх тайвныг хамгаалах Хорооны төлөөлөгч Сэнг-Лим Неу

1. Энэтхэг-хятадын хойгийн орнуудын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд учирч байгаа саад бэрхшээлийн талаар ярьж өгнө үү?

Энэтхэг-хятадын хойгийн гурван орны ард түмэн дайнд нэн залхаж, амар жимэр аюул заналгүй байж хөрш болон дэлхийн бүх улстай эв найрамдалтай хамтран ажиллах чин эрмэлзэлтэй байдаг юм.

Дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас хойш Энэтхэг-хятадын хойгийн орнуудад ямар тайван цаг байсангүй. Америкийн империалистүүд Бээжингийн тэлэн эзлэх их гүрний дээрэнгүй үзэлтнүүдтэй хуйвалдаж хүйтэн дайныг өдөөж, зэвсэглэлээр зогсоо зайгүй хөөцөлдөн цөмийн дайнд бэлтгэхдээ Энэтхэг-хятадын хойгийн улс түмний тусгаар

тогтнох хүсэл эрмэлзлэлийг мэсийн хүчээр мохоож, манай орнуудын газар нутгийг шинэ тулалдааны зэр зэвсэг турших талбараа болгох гэж улайран хөөцөлдөж байна. Тухайлбал манай Кампучи пол потын маоист дэглэмийн золиос болж байлаа. Иенг Сари гурван сая кампучи хүний амь насыг бүрэлгэн манай орныг бүх хөрш орнуудтай эвдрэлцүүлж байсан юм. Пол Потын дэглэмийг устгасны дүнд манай ард түмэн тайван нөхцөлд эвдэрч сүйдсэн улс орноо сэргээж эхэлсэн юм.

Тэрхүү харгис хүч манай улсын бүтээн байгуулалтад саад хийхийг оролдон пол потын дээрэмчдийг цуглуулан зэвсэглэж манай тосгод руу явуулж «Ардчилсан Кампучи» гэдэг ичгүүрт царайг нь «эвслийн засгийн газрын» нүгэлт багаар далдалж байна. Энэ бүхэн нь ардын засгийг түлхэн унагаж, Пномпеньд Пол Пот, Иенг Сарийн маоист болоод яргачдын дэглэмийг оруулж ирэх гэсэн санаархал юм.

Гэтэл АСЕАН-ы зарим бүлгийнхэн гүжир гүтгэлэг болон хуурмаг мэдэгдэл хийж байна. Тухайлбал Кампучид, Вьетнам л аюул занал учруулж, Кампучид вьетнамын цэрэг байрлаж байгаа нь л хурцадмал байдлын эх үүсвэр болж байна гэх буюу энэ цэрэг нэгэн цагт Тайланд руу довтолж, улмаар дайныг тэлэн өргөжүүлэх мэтээр сурталчилахыг оролдож байна. Чухамдаа 600 гаруй жилийн тэртээгээс Тайланд л манай улс руу довтолж хэд хэдэн удаа эзлэн авч байсан билээ.

Эдүгээ Тайландын газар нутагт л Пол Потын дээрэмчид болон Кхмерийн бусад харгис хүчин бөөгнөрч байгаа юм. Энэхүү дээрэмчдэд Тайландын нутгаар дамжуулан зэр зэвсэг илгээж байгаа юм. «Ардчилсан Кампучийн засгийн газар» гэгчийн гол оролцон тоглогчид Бангкок юм уу Тайландын бусад газар нутагт л уулзалдаж хуйвалдаан гаргаж байгаа юм. Чухамдаа гол аюул нь бүр цаанаас тухайлбал Вашингтонтой хуйвалдсан Бээжингийн зүгээс ирж байгаа юм. Гэхдээ АСЕАН-ы болон Бангкокийн харгис бүлгийнхний тусламжгүйгээр энэ аюул занал биелэлээ олж чадахгүй юм.

Ийм учраас Зүүн Өмнөд Азийн орнууд Зүүн Өмнөд Азид энх тайвныг тогтоож чадна гэж бид бат итгэж байдаг юм.

Бүх Энэтхэгийн энх тайван, эв санааны нэгдлийн байгууллагын төлөөлөгч Госвами Динеш

1. Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгоход ямар бэрхшээл учирч байна?

Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгох асуудал хэд хэдэн тодорхой бэрхшээлтэй тулгарч байна. Юуны өмнө АНУ-ын засгийн газрын баримталж байгаа байр суурь гол бэрхшээл учруулж байна. Их Британи улс 60-аад оны эхээр Суэцийн сувгаас зүүн тийш зэвсэгт хүчнээ татан гаргах тухай мэдэгдсэнээс хойш АНУ энэ бүс нутагт тэнгисийн зэвсэгт хүчнээ байгуулах программыг хэрэгжүүлэх замаар Энэтхэгийн далайд жанжлах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн юм. Диего Гарси арал дээр тэнгисийн цэргийн бааз байгуулахаас эхлээд АНУ Энэтхэгийн далайн бүс нутагт хэд хэдэн баазыг байгуулж эхэлсэн билээ. Ираны шагын дэглэм унасны дараа Энэтхэгийн далайгаас хэдийгээр АНУ 10,000 милийн зайд орших боловч америкийн аюулгүй байдлыг хамгаалах тухай олонтоо ярих болсон юм. 1979 онд хуралдсан Шри-Ланкагийн төлөөлөгчийн даргалсан НҮБ-ын тусгай хорооны санаачилгаар «Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгон тунхаглах» тухай асуудлыг авч хэлэлцэх олон улсын бага хурлыг 1931 онд хуралдуулах санаачилгыг дэвшүүлсэн билээ. Гэтэл АНУ дээрх бага хурлыг хийлгэх саналыг хэрэгжүүлэхэд янз бүрийн бэрхшээл уч-

руулсаар байгаа төдийгүй, харин ч дээрх бага хурлыг тааламжтай нөхцөлд хуралдуулахыг дэмжиж байгаа ЗХУ-тай хэлэлцэн ярилцахаас аль болохоор зайлсхийж байна. Филлипин, Австрали зэрэг оронд АНУ даралт шахалт үзүүлж тэдний агаарын болон тэнгисийн цэргийн байгууламжийг Энэтхэгийн далайд байрлуулах талаар хамтран ажиллаж байгаа нь энэ бүс нутгийн байдлыг улам ээдрээтэй болгож байгаа юм. Ийнхүү Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгохын эсрэг Америкийн баримталж байгаа байр суурь, энэ бүс нутгийн зарим улсын тууштай биш нэгдэл нягтралгүй байдлаас болж Энэтхэгийн далайг энхийн бүс болгох замд бэрхшээл учирсаар байгаа юм.

2. Энэтхэгээс хөрш орнуудынхаа талаар баримталж байгаа Энх тайванч бодлогын талаар ярьж өгнө үү?

Энх тайвны үйл хэрэг ялна гэдэгт Энэтхэг улс ямагт найдан итгэдэг юм. Энэтхэгийн ард түмний үндэсний тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэн боссон тэр жилүүдэд ч гэсэн бид зөвхөн хүч хэрэглэхгүй зарчмыг баримтлан байсан төдийгүй энх тайван, тусгаар тогтнол, дэвшил л хөгжлийн төлөө тууштай тэмцэж байсан юм. Энэтхэгийн гадаад бодлого энх тайванд тулгуурладаг юм.

Хэлэлцээрийн ширээний ард харилцан ярилцаж байгаад шийдвэрлэж болохгүй тийм асуудал байхгүй гэдэгт бид итгэж байна. Манай гадаад бодлогын тулгын гурван чулууны нэг нь улс үндэстэн бүртэй найрамдалт харилцаатай байх явдал юм. Бид хөрш зэргэлдээ улсуудтайгаа харилцах харьцаандаа энэ зарчмаа хатуу баримталдаг юм. Энэтхэгийн-засгийн газар өөрийн хөршүүдтэйгээ харилцан бие биеийнхээ эрх ашигт нийцсэн янз бүрийн гэрээ хэлэлцээр байгуулсан билээ. Энэтхэг Улс Балбатай худалдаа, найрамдлын гэрээтэй. Энэтхэг Бангладеш хоёр маш сайн харилцаатай бөгөөд зарим нэг асуудал тухайлбал гол мөрний усыг хувааж ашиглах асуудлыг өндөр хэмжээний төлөөлөгчдийн хооронд авч хэлэлцэж шийдвэрлэж байна.

Энэтхэг улс Пакистантай Симлагийн хэлэлцээр байгуулж хоёр орны нэлээд ээдрээтэй асуудлыг зохицуулав.

Энэтхэгийн эсрэг Хятад түрэмгийлэл хийсэн үнэн боловч манай улс Хятадтай харилцах харилцаандаа ямагт найрамдлыг эрхэмлэдэг юм.

1970 оны 8-р сард Делид болсон нэгэн семинар дээр манай ерөнхий сайд Индира Ганди Энэтхэг улсын олон улсын бодлогын талаар ярихдаа: «Найрамдлын замаар өөр хоорондын дайсагнасан харилцааг хэвийн болгож болох юм гэж би бодож байна» гэж хэлсэн юм.

Манай гадаад бодлогын ноён нурууг босгосон Бандида Жавахарлал Неру Энэтхэгийн парламентад хэлсэн үгэндээ: «Бидний гол зорилго маргаан дээрээ үндэслэж маргахдаа биш харин адил төстэй асуудлаараа харилцан санаа бодлоо ярилцахад оршино» гэсэн байдаг. Энэ бол манайхаас асуудалд хандах хандлагын үндэс суурь нь юм. Энэ философи манайхаас улс оронтой явуулах харилцаа, нэн ялангуяа хөрш зэргэлдээ улсуудтайгаа явуулах харилцааны үндсэн чиглэл билээ.

**Р. Отгон,
М. Зэнээ**